



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-13

<i>1. Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, 2019 оны 07 дугаар сарын 09, 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2026.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	4-13
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороодын
05 дугаар сарын 12-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 58 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 50 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Алдаржавхлан, О.Амгаланбаатар, Э.Болормаа, П.Ганзориг, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаясгалан, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Л.Гантөмөр, Б.Жаргалан, Ц.Мөнхбат, Ч.Номин, Л.Оюун-Эрдэнэ, Б.Түвшин, Б.Тулга, Ө.Шижир, Б.Чойжилсүрэн, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга.

Нэг.Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, 2019 оны 07 дугаар сарын 09, 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2026.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, мөн хэлтсийн шинжээч Х.Еркегүл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ням-Очир, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Анх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Шишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Б.Гандиймаа, А.Наранцэцэг, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд З.Мэндсайхан, хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, М.Бадамсүрэн, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Ням-Очир, мөн яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Анх-Оргил нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар үг хэлэв.

Н.Наранбаатар: Улаанбаатар хотноо 2017 оны 05 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, 2019 оны 07 дугаар сарын 09, 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 13
Бүгд: 30
56.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 58 гишүүнээс 32 гишүүн хүрэлцэн ирж, 55.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 14 цаг 50 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хороодын хамтарсан хуралдааны ирц бүрдсэн тул 2026 оны 5 сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Чинбаатарын Анар, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Нацагдоржийн Батсүмбэрэл, Дуламын Бум-Очир, Дашдондогийн Ганбат, Хажыкбэрын Жангабыл, Сүрэнжавын Лүндэг, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Ганбатын Очирбат, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Ганзоригийн Тэмүүлэн, Ганбатын Хосбаяр, Жадамбын Энхбаяр, Лутаагийн Энхнасан, Арвижихын Эрдэнэбүрэн, Норовын Алтанхуяг, Далайн Батбаяр, Ренчиндоржийн Батболд, Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь, Жадамбаагийн Баясгалан, Хөххүүгийн Болормаа, Гомбын Ганбаатар, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Даваахүүгийн Пүрэвдаваа, Даваагийн Цогтбаатар, Доржсүрэнгийн Үүрийнтуяа.

Байнгын хороодын өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг. Улаанбаатар хотноо 2017 оны 5 сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төсөл, Засгийн газар 2026 оны 4 сарын 22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг хэлэлцье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Загджавын Мэндсайхан Сангийн сайд Дэлгэржаргал тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ганзориг Тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Еркегүл Тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн шинжээч. Энэ Сангийн яамнаас оролцох бүрэлдэхүүн.

Одоо Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамнаас Баяраа тус яамны ТНБД, Ням-Очир тус яамны Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Анх-Оргил, тус яамны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга ийм бүрэлдэхүүн байна.

Улаанбаатар хотноо 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Сангийн сайд Загджавын Мэндсайхан танилцуулна аа.

Мэндсайхан сайдыг урьж байна.

3.Мэндсайхан: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Төсвийн байнгын хорооны дарга болон Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хооронд 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр, жилийн 0.15 хувийн хүүтэй, 28 жилийн хугацаатай, үндсэн төлбөрөөс 5 жил чөлөөлөгдөх нэн хөнгөлөлттэй 50 сая еврогийн нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрийг байгуулж Улсын Их Хурлаар соёрхон баталсан. Энэхүү 50 сая еврогийн нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилтийг Засгийн газрын 2018 оны 25 дугаар тогтоол 2024 оны 94 дүгээр тогтоол, 2025 оны 113 дугаар тогтоолын дагуу тус тус хуваарилсан.

Дээрх зээлийн хүрээнд хэрэгжүүлэхээр тогтсон нийт 5 төслөөс 3 төсөл амжилттай хэрэгжиж бүрэн дууссан бөгөөд аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинэ барих төсөл 84 хувь, Эрдэнэт хотын хатуу хог хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулах Хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл 90 хувийн гүйцэтгэлтэй тус тус хэрэгжиж байна. Дээрх аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх шинээр барих төслийн хүрээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс, Дорнод аймгуудад хоногт 3 мянган м³-ээс 5 мянган м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барих ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан бөгөөд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Увс аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил бүрэн дуусаж туршилт тохируулгын ажил хийгдэж байгаа бол Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийн ажил 23 хувьтай хэрэгжиж байна.

Өнөөдрийн байдлаар нэн хөнгөлөлттэй зээлийн 71 хувь буюу 35.5 сая еврог ашиглаад байгаа бөгөөд үлдсэн 14.5 сая еврогийн зээлийн ашиглалт хүлээгдэж байна. Дээрх нөхцөл зээлийн хэрэг ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжих төслийг БНПУ-ын гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг айлын талд хүргүүлэх хугацаа 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдөр дуусгавар болсон тул хэрэгжиж буй 2 төслийн хэрэгжилтийн нөхцөл байдлаас шалтгаалан гэрээ байгуулах хүчинтэй хугацааг 2016 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл сунгах мөн уг хэлэлцээрийн 8 дугаар зүйл Ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор санхүүжилтийг олгож дуусахаар заасан хугацааг 3 жилээр сунган 8 жил болгоход нэмэлт, өөрчлөлтийг Польшийн талтай эцэслэн тохиролцоод байна. Энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын 2026 оны 4 сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж Улсын Их Хурлын холбогдох байнгын хороодтой зөвшилцөхөөр Засгийн газрын 2026 оны 14 дүгээр хурал хуралдааны тэмдэглэл гарч Эдийн засгийн байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжигдсэн болно.

БНПУ-ын Засгийн газартай байгуулсан нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд гүйцэтгэгчтэй байгуулах гэрээний хүчинтэй хугацааг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах хэлэлцээрийн хүрээнд

байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш санхүүжилтийг 8 жилийн дотор олгож дуусах нэмэлт, өөрчлөлтөд гарын үсэг зурах эрх олгох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Мэндсайхан сайдад баярлалаа.

Зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Анар танилцуулна аа. Анар гишүүн микрофоныг өгөөрэй.

Ч.Анар: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ. Эдийн засгийн байнгын хороо нь 2026 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ. Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын 2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр 50 сая еврогийн нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийг байгуулсан.

Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 25 дугаар тогтоол, 2024 оны 94 дүгээр тогтоол, 2025 оны 113 дугаар тогтоолын дагуу 5 төслийг хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд өнөөдрийн байдлаар 3 төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан байна.

Харин аймгийн иргэдийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх шинээр барих төсөл 84.5 хувь, Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл 90 хувийн хэрэгжилттэй байна аа. Нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд тус хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших санхүүжилтийг 5 жилийн дотор олгож дуусахаар заасан.

Тус төслийн түлхүүр гардуулах гэрээ 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд санхүүжих эцсийн хугацаа 2025 оны 2 дугаар сарын 20-оор дуусгавар болсон тул төслийн үлдэгдэл болох 0.9 сая еврог санхүүжүүлэхийн тулд Нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан хугацааг өөрчлөх шаардлага үүссэн байна. Иймд аймгуудын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх шинээр барих төслийн хүрээнд баригдах Дорнод аймгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн худалдан авах ажиллагааг зарлаж гэрээ байгуулахад нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 2-т нэмэлт, өөрчлөлт оруулж гэрээг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах тус байгууламж болон Орхон аймгийн хатуу хог боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын гүйцэтгэл удаашралж байгаатай холбогдуулан барилга байгууламжийг дуусгаж эцсийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан санхүүжилтийн эцсийн хугацааг 3 жилээр сунгах мөн Засгийн газрын тогтоолоор шинэчлэн хуваарилсан нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрийн 50 сая еврогийн хуваарилалтыг

баталгаажуулах нэмэлт, өөрчлөлтийн хавсралтын тогтоолын төслийг боловсруулсан байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц 5 мянган м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай, цэвэрлэх байгууламжийг 10 мянган м3 болгож өсгөснөөр өнөөдрийн үнийн дүн нэмэгдэж байгаа эсэх, улсын төсвөөр цэвэршүүлэх байгууламжийг үүнтэй адил багтаамжтайгаар барьсан тохиолдолд төсөвт өртгийн үнийн зөрөө хэд байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн санхүүжих дүн нэмэгдээгүй зөвхөн хугацааг сунгаж байгааг тодруулж төслүүдийн хэрэгжилтийн явцыг бодитой дүгнэсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ундраа саарал усны хэрэглээг хөхүүлэн дэмжигдэх тал дээр тарифын болон тарифын бус урамшууллын механизм бий болгох талаар, хариуцсан салбарын байгууллага ямар бодлого баримталж байгаа талаар, Сангийн яамнаас саарал усны хэрэглээг дэмжиж эсвэл эрчим хүчний хэрэглээг багасгаснаар гаргах зардал нь буурах, төлөлтийг цаашид хийх эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүд санал хэлээгүй болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшилцөх эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Анар гишүүнд баярлалаа. Зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Бадамсүрэн гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүн асуулт асууя.

Г.Ганбаатар: Энэ ч аль 2017 онд авсан зээл юм байна шүү дээ. Тэгээд ингээд өөрчлөлт орж явсаар байгаад 2025 онд үндсэндээ хугацаа нь дуусчхаж байгаа юм байна тиймээ. Түрүүнд тэр Сангийн сайдын хийсэн мэдээлэл дотор энэ 50 сая евроноос 35 сая еврог нь ашигласан гээд 15 сая еврог нь яагаад ашиглаагүй юм бол? Гэтэл сая энд нөгөө Байнгын хорооны дүгнэлт уншсан чинь 0.9 сая еврогийн үүнийг нь ашиглачихмаар байгаа юм гэсэн санаа гарч ирж байх юм.

Дээрээс нь энэ төслүүдээс энэ чинь нэг Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Увс, Завхан аймгийн л бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх шинэчлэл төсөл байсан юм байна 9 жилийн өмнө өнгөрсөн зээл. 3 төсөл нь амжилттай хэрэгжсэн гэж бусад нь яасан юм? Сая өгсөн мэдээлэл дотор 3 төсөл нь амжилттай хэрэгжсэн гэж. Эдгээр асуултуудыг хэн хариулах вэ?

Н.Наранбаатар: Сангийн сайд Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Дорнодын тэр 3 төсөл нь хэрэгжээд дуусчихсан. 50 сая еврогийн 34 аравны хэд билээ дээ. Үлдэгдэл нь Дорнодын ус цэвэрлэх байгууламжийн тендерийн сонгон шалгаруулалт нь зарлагдаад явж байгаа. Нөгөөх нь 0.9 нь юу билээ. Орхоны санхүүжилтийн үлдэгдэл байж байгаа. Тэгээд энэ хугацаа сунгаж байгаа нь энэ ондоо багтаад энэ ажлууд маань дуусаж байгаа юм. Яг төслийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээллүүдийг БХБЯ-ныхан нэмээд өг дөө, хариулт.

Н.Наранбаатар: Хэн хариулах вэ? 5 номер албан тушаал нэрээ хэлээд хариул.

М.Ням-Очир: Хот байгаль барилга орон сууцжуулалтын яам Нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ням-Очир Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Манай яаман дээр Польшийн зээлийн хөрөнгөөр нийтдээ 5 аймгийн цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл хэрэгжиж байгаа.

Эдгээрээс 2025 оны 9 сард Баян-Өлгий аймгийн хоногт 4200 м3 бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламж комисс хүлээж аваад туршилт тохируулгын ажил эхлээд явж байна. Увс, Говьсүмбэр, Завхан аймгуудын цэвэрлэх байгууламжийг өнгөрсөн 2025 оны 11, 12 дугаар саруудад улсын комисс хүлээж авсан. Одоо туршилт тохируулгын ажил эхлээд бэлэн болоод ингээд явж байгаа.

Дорнод аймгийн хувьд бол анхны төлөвлөлтөөр 5 мянган м3 хоногт бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж байгуулахаар ингэж төлөвлөгдсөн байдаг. Гэвч явцын дунд.

Н.Наранбаатар: Гүйцээгээд хариулчихъя.

М.Ням-Очир: Явцын дунд орон нутгаас ирсэн саналын дагуу 10 мянган м3 болгосон. Ингээд 10 мянган м3 болгоод ахиж зураг төсөл ТЭЗҮ боловсруулагдаж 2023 онд анхны зураг төсөл боловсруулагдсан байдаг. Энэ зураг төслөөр нийтдээ 63 тэрбум төгрөгийн төсөв магадлагдсан. Тэгээд энэ дүндээ багтахгүй учраас технологийн шийдлийг ахиж сонгоод 2025 оны 9 сард дараагийн 2 дахь техникийн хувилбараар зураг төсөл хийгдэж 43 тэрбум төгрөгөөр магадлал батлагдсан байгаа.

Н.Наранбаатар: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Өнөөдөр чинь ингээд 2026 оны 5 сарын 12. 2026 оны 12 сарын 31-нд тэгээд энэ үлдсэн ажил нь амжих уу? Тэр 0.9 сая евро гээд сая Байнгын хорооны дүгнэлтэд гарч байна. Тэр ямар учиртай юм?

Н.Наранбаатар: Хэн нэмж хариулах вэ? 9 номер.

Б.Ганзориг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Ганзориг. Энэ 0.9 сая евро бол Орхон аймаг дээр тусдаа хийгдсэн хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийн үлдэгдэл санхүүжилт байгаа. Тэр нь бол 9 сая еврогийн гэрээтэй төсөл хэрэгжсэн. Уг төсөл маань улсын комисс ажилласны дараа гэрээндээ заасны дагуу үлдэгдэл 10 хувийн төлбөр буюу 0.9 сая еврогийн төлбөрийг төлөхөөр ийм байгаа юм аа. Тэгэхээр энэ төлбөрийг хийхийн тулд бас энэ нөгөө 5 жилийн

хугацааг 3 жилээр сунгаад 2026 оныхоо 12 сарын 31-нд багтаад төлбөрөө хийчих ийм зохицуулалттай байгаа.

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн асуулт асууна.

М.Бадамсүрэн: БХБЯ-наас асууя.

Нэгдүгээрт энэ Дорнод аймагт хэрэгжиж байгаа 10 мянган м3-ийн бохир цэвэрлэх байгууламжийн ажил удааширсан шалтгаан юу вэ? Нэг.

Хоёрдугаарт нь энийг ашиглалтад оруулах ийм сонирхол манай БХБЯ-нд ер нь байгаа юу?

Гуравдугаарт нь энэ ач холбогдолтой ер нь олон улсын зээлээр хэрэгжүүлж байгаа төслийг тавих хяналт тийм сайн биш байна гэж би үзэж байгаа. Жишээлбэл энэ услалтын систем гээд манай ХАА-н салбарт хийгдсэн, зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах ажил нь амжилтгүй болсон. Тэрэн шиг энэ дээр зөвлөх үйлчилгээний шалгаруулалтад нь ямар газар шалгарсан байдаг юм бэ? Тэгээд энэ нь үүргээ биелүүлсэн юм уу? Эсвэл зөвлөх үйлчилгээг ерөөсөө шалгаруулаагүй юм уу? Яг юунаас болоод ингээд ийм олон жил болж байгаа юм бол? Тэгээд хугацаа сунгах дээрээ тулчихсан. Би сая Гомбын Ганбаатар гишүүнтэй бас адилхан асуултыг давхар асууж байгаа юм. Одоо ингээд нэг 6, 7 сарын хугацаатай сунгаад энэ хооронд амжих юм уу ашиглалтад орж. Тэгээд энэ чинь ингээд хүүгийн төлбөр яваад байдаг, валютын ханшийн өсөлт яваад байдаг. Өсөлт яваад байдаг. Тэгээд энэний хохирлыг ер нь хэн хариуцах вэ? Албан тушаалтан хариуцах уу эсвэл нэг байгууллага хариуцах уу, эсвэл Дорнод аймгийн 85 мянган иргэн энэ дээр буруутай юу? Яг би энэ дээр их тодорхой хариулт авмаар байна. Яг яагаад ингээд энэ хэрэгжихгүй яваад байгаа юм бол оо? Ер нь энэ зээлээр олон улсын зээлээр авч байгаа хөрөнгийг чинь тэгээд бараг зүгээр авч байгаа юм шиг бодоод байх юм. Үгүй шүү дээ энэ чинь хүүтэй нь ингээд ард түмэн эргээд төлнө. Тэгээд энэ дээр хандлагын ийм нэг том ялгаа байгаад байгаа юм. Энийг цаашдаа ер нь ийм зээлийн олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хөрөнгийг энэ ямар шалгуураар, яаж хяналт тавих ёстой юм бэ? Энийг их нарийн чанд болгож хууль тогтоомжийг зөв өөрчлөх шаардлагатай юм байна гэж үзэж байгаа. Яг энэ дээр Барилгын яам яг гардаж хэрэгжүүлж байгаагийн хувьд яг ийм зүйл байна гэдэг юм байна уу? Нэг.

Хоёрдугаарт нь энэ Чойбалсан хотын цэвэр ус түгээх энэ систем дээр ямар шинэчлэл хийхээр ийм технологийн шинэ өөрчлөлт хийхээр бодож төлөвлөж байгаа зүйл ер нь байгаа юу? Хуучин Оросын үеийн социалист үеийн технологиор нэг элсээр шүүдэг технологиор байгаа. Тэгээд энийг цаашид шинэчлэх талаар мэргэжлийн яам ямар нэгэн бодсон зүйл байгаа юу? Энэ дээр би маш тодорхой хариулт авмаар байна. Одоо орчин үед өөр технологи нэвтэрчихсэн. Хэрлэн голын ай сав өөрөө төмрийн ислэгтэй. Яг энд нь тохирсон ийм технологи сонголт дээр хийсэн судалгаа байна уу? Яг энэ дээр тодорхой хариулаач.

Н.Наранбаатар: 7 номер хариулна.

Б.Анх-Оргил: Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яамнаас Анх-Оргил Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. 1, 3-тай холбоотой асуултад хариулъя. Энэ төсөл маань анх 2017 онд манай яамны захиалгаар Засгийн газрын тогтоолоор хэрэгжүүлэхээр батлагдсан. 2017 он болон 2018 онд энэ төслийн

гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах ажил нь амжилтгүй болсон учраас хугацаа хойшлогдсон. Хэлэлцээрийн хугацаа энэ хугацаанд дууссан учраас 2021 онд хугацаа сунгагдсаны дагуу бид нар 2021 онд Дорнод аймаг дээр гүйцэтгэгчийг амжилттай сонгон шалгаруулсан. Ингээд 2021 оны 7 сард сонгон шалгаруулаад тухайн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ маань 2021 оны 12 сард ашиглалтад орсон. Энэ хугацаанд бүүр анхны 2017 онд төлөвлөж байсан. Зарим нэг хүчин чадлыг өөрчлөх шаардлага гарсан. Яагаад гэвэл Дорнод аймгийн өөрийнх нь хүн амын өсөлт, дээрээс нь хотжилт барилгажилтын тоо жил ирэх тусам 20-100 энэ орон сууцаар нэмэгдсэн ийм тоонууд гарсан учраас энэ цэвэрлэх байгууламжийн хүчин чадлыг 5 мянга байсныг 10 мянга болгох шаардлага гарсан учраас энэ дээр ийм хугацаа алдсан асуудал байгаа.

Гуравдугаар дугаар асуудлын хувьд болохоороо гадаадын зээл тусламжаар хийгдэж байгаа энэ 5 аймгийн цэвэрлэх байгууламжийн энэ төслүүд дээр манайх орон нутгаас БХБ-ын газар, Барилгын хөгжлийн төв, дээрээс нь манай яамны харьяа болох нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бас ингээд 3 үе шатын байгууллагаар хяналтаа тавиад хэрэгжүүлж байгаа.

Н.Наранбаатар: 9 номер.

Б.Ганзориг: Бадамсүрэн гишүүний асуултад нэмж хариулъя. Сангийн яам Ганзориг гишүүний асуултад байсан сая нөгөө Польшийн Засгийн газартай байгуулсан энэ 50 сая еврогийн хугацааг энэ нөгөө айлын талд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээ хүргүүлэх хугацааг бид нар 2026 оны 12 сарын 31 хүртэл сунгаж байгаа. Энэ маань өөрөөр хэлбэл энэ ондоо БХБЯ маань худалдан авах ажиллагаагаа хийж дуусаад айлын талд 12 сарын 31-дээ багтаад гэрээгээ хүргүүлчихвэл тэр хугацаанд хүргүүлснээс хойших санхүүжилтийг бол саяын бас Ганбаатар гишүүний асуултад дурдаж байсан 3 жилийн хугацаагаар сунгачихсан хугацаандаа санхүүжилтээ аваад явчих ийм боломжтой байгаа юм. Тэгэхээр зөвхөн гэрээг хүргүүлэх хугацааг бид нар бас энэ дээр сунгаж байгаа.

Дараачийн асуулт нь бол бид нар энэ 50 сая евро дээр ямар нэгэн хөрөнгө баталгаажуулсны төлбөр төлөхгүй байгаа. Энэ 28 жилийн хугацаатай жилийн 0.15 хүүтэй хүүтэй зээл байгаа. Энэ зээлд өнөөдрийн байдлаар бол 130.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр одоогоор төлсөн байгаа ашигласан зээлийнхээ хэмжээнд. Өөр ямар нэгэн.

Н.Наранбаатар: Нэмээрэй тэр цэвэр устай холбоотой 5 номер.

М.Ням-Очир: Өнгөрсөн 2019-2022 оны хугацаанд Монгол Улсын бүх төв суурин газрын ахуйн усанд шинжилгээ хийсэн. Энэ шинжилгээгээр нийтдээ 40-өөд хувь нь ундны усны шаардлага хангахгүй гэсэн ийм судалгаа гарсан байдаг. Энэний хүрээнд энэ шинжилгээнийхээ дүнг бүлэглээд тухайн ойролцоо шинжилгээ өгсөн усны үзүүлэлтүүд дээр гэсэн үг. Тэгээд тухайн ундны усны шаардлага хангахгүй байгаа усыг ямар технологиор энийг нарийвчилж хүний эрүүл мэнд, стандартын шаардлага хангасан болгох вэ гэдэг дээр бид нар холбогдох технологийн судалгааг хийлгэхээр АХБ-нд ингээд хүсэлт тавьчихаад байж байгаа. Энэний хүрээнд Монгол Улсын хэмжээнд бүх төв суурин газрууд дээр ундны усны шаардлага хангуулахын тулд ямар ямар технологиудыг хэрэгжүүлэх вэ гэсэн энэ чиглэлийн ажил иймэрхүү байдалд хийгдэж байна аа.

Н.Наранбаатар: Бадамсүрэн гишүүн тодруулъя.

М.Бадамсүрэн: Баярлалаа. Энэ төслийн үйл ажиллагааг ашиглалтад оруулахад БХБЯ захиалагчийн хувьд бол онцгой анхаарч төлөвлөсөн хугацаанд нь заавал ашиглалтад оруулаарай гэдгийг онцгой энэ дээр ард түмний өмнөөс мандат үүрчихсэн гишүүний хувьд онцгой анхааруулж хэлье. Тэгээд янз бүрийн байдлаар гацаа тотгор үүсгэдэг янз бүрийн ийм зүй бус юм байх юм бол энэ дээр тийм нөлөөлөл орж ирвэл бас тойргоос сонгогдсон гишүүдэд мэдээлээрэй гэж хэлье. Тэгээд яагаад ингээд удаашраад байгаа шалтгааныг нь ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм. Наана чинь станц нь өргөтгөчихсөн, дулаан, цэвэр усны шугамыг нь өргөтгөчихсөн. Бохиросоо болоод олон барилга орж чадахгүй байгаа шүү дээ. Энэ бодлогын том алдаа болж байгаа байхгүй юу.

Хоёрт тэр технологио хурдан нэвтрүүлээрэй. Ямар ч удаан судалдаг юм бэ дээ хэдэн жил ч судлав даа энэ хүн амын ундны усны асуудлыг. Тэгээд дорвитойхон.

Н.Наранбаатар: Би нэг асуулт асуучихъя. Одоо энэ яг энэ гэрээний юутай холбоотой биш. Энэ 330 сумын яг хэчнээн нь цэвэр ус, инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжтай байна вэ? Тэр тоо баримт байна уу үгүй юу.

Хэрвээ одоо энэ үлдсэн сумдуудаа нэгмөсөн ийм инженерийн шугам сүлжээтэй болгоё гэвэл хэдий хэмжээний төсөв ер нь багцаагаар шаардлагатай байгаа юм. Одоо нэг суманд дунджаар энэ инженерийн шугам сүлжээ тавихад төсөв ямархуу байгаа юм гэсэн ийм зүйлийг асууя. Та бүхэнд тооцоо судалгаа байна уу үгүй юу? Одоо 21 дүгээр зуун гарчхаад байхад чинь гадаа жорлонтойгоо л дотуур байр нь гадаа жорлонтой, сургууль эмнэлэг бүгдээрээ л гадаа жорлонтой л байна шүү дээ. Тэгээд бүх сумдууд маань 100 жилээ хийгээд дуусаж байх шиг байна. Тэгээд ер нь 1 далайлтаар нэг төсөв дээрээ нэг бол 2 жил, 3 жилдээ үе шаттайгаар ингээд сумдуудаа холбочихмоор л харагдаад байдаг юм. Зарим аймаг бол 100 хувь сумдуудаа холбосон байгаа шүү дээ. Энэ дээр тооцоо судалгаа байна уу? 5 номер.

М.Ням-Очир: Өнгөрсөн оны сүүлээр хийсэн судалгаагаар 330 сумаас 181 сум нь ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээтэй байна гэсэн ийм судалгаа гарсан. Гэвч энэ ашиглалттай холбоотой асуудлууд байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумдуудад шугам сүлжээ барьж байгуулаад байна. Нийтдээ нэг өнөөдрийн байдлаар харахад 12 орчим тэрбум төгрөг шаардвал эхний ээлжийн ус хангамж зөвхөн ариутгах татуургын чиглэлээр шугам сүлжээг дундаж хэмжээний сум дээр барьж байгуулах боломжтой. Ер нь бол цаашдаа орон нутагт тэр тусмаа сумд дээр энэ шугам сүлжээний ажлыг хийе гэвэл орон нутгаас мэргэжилтэй боловсон хүчнийг бэлдэх шаардлагатай байна. Бариад өгөхөд дараа нь ашиглалтыг нь хариуцах газар тэнд байдаггүй. ЗДТГ-ын нэр дээр ашиглагддаггүй үлддэг. Мөн шугам татсан тохиолдолд ААН айл өрхийг холбох ажлыг бас зохион байгуулахгүй бол хэдий бид нар шугамыг татаад өгдөг боловч хэрэглэж холбогдоход их хүндрэлтэй байдаг. Өөр нэг хүндрэл бол орон нутагт ерөнхийдөө дулаанаа концессын гэрээ гэдгээр өгчихсөн байдаг.

Цэвэр усны шугам бол нөгөө дулааны шугамтайгаа хамт уялдаж хэрэглэгчдэд хүрэх ийм шаардлагатай байдаг. Энэ зохицуулалтыг хийхийн тулд нөгөө хувийн хэвшлийн концессын гэрээ хэрэгжүүлэгчдээ бас техникийн хувьд тохирох тохирохгүй янз бүрийн асуудлууд гардаг. Цаашдаа бол ерөнхийдөө хэрвээ сумд дээр үнэхээр шаардлагатай бол зүгээр миний өөрийн харж байгаагаар тодорхой

хэмжээний шалгуур тавиад дундын сан үүсгээд тэндээ тодорхой хэмжээний айл өрхөө холбох мөнгө бүрдүүлдэг ч юм уу орон нутгаасаа тэр барилга байгууламжийн шугам сүлжээний ашиглалт дээр ажиллах мэргэжилтэй бүр боловсон хүчнээ бэлдчихсэн байх шаардлагатай ч байдаг юм уу иймэрхүү тэр ашиглалтын зардлыг орон нутгийнхаа сумынхаа төсөвт тусгах тийм боломж нөхцөлтэй болсон. Иймэрхүү л тохиолдолд л уул нь хөрөнгө оруулалт хийвэл цаашдаа хөрөнгө оруулалтын маань үр өгөөж сайн байх болов уу гэсэн ийм бодолтой байдаг.

Н.Наранбаатар: Ер нь сумандаа орон нутгийн өмчит байгуулаад тэр орон нутгийн өмчит нь тэр халаалт дулаан, цэвэр бохир хариуцаад тог цахилгаан одоо сумууд чинь засмал замтай болчихсон, гэрэлтүүлэгтэй болчихсон, хогийн асуудал ингээд явчихвал уг нь зүгээр байгаа юм. Тэгэхээр энийг та бүхэн цаашаа судлаарай. Тэгээд надад манай Байнгын хороонд саяынхаа ярьсан судалгаа гаргаад өгчхөөрэй. 181 сум холбогдсон юм байна. Үлдсэн ямар ямар сумууд холбогдоогүй байгаа юм гээд, хүндрэл бэрхшээл юу байдаг юм бичээд өгөөрэй.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зээлийн хэлэлцээртэй холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн үг хэлье.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Энэ Польшийн Засгийн газартай байгуулсан нөхцөлт зээлийн нөхцөл нь бол үнэхээр гоё нөхцөлтэй зээл тухайн үед авч байсан юм байна. 2017 он гэдэг чинь. Тэгээд энэ дээр юу харагдаад байна гэхээр харьяа яамдууд засаг ээлжилж барьж байгаа Засгийн газар, сайд нар маш хариуцлагагүй ажиллаж байгааг энэчээ харуулаад байна аа. Ийм гоё нөхцөлтэй зээл ороод ирж байхад тухайн үед нь хамаг асуудлуудыг нь маш яаралтайгаар ажлуудыг нь шуурхай шуурхай хийгээд явчхаж болдоггүй байсан юм уу? Байж байж байгаад л бид нар ийм зээлийн ашиглалтыг сайжруулмаар байна гээд л нэг Улсын Их Хурал дээр баахан хугацаа сунгадаг. Одоо энэ хамгийн сүүлийн жишээ нь сая бид нар нийслэл дээр тэр Сэлбэ төвийг барьж байгуулах гэж байна, газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах гэж байна, Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг барьж байгуулах гэж байна. Энийгээ улсын төсөвт хамаагүй байдлаар шийдчихье гээд ингээд Улсын Их Хурлыг л янз бүрийн асуудалд шахаад байдаггүйгээр хийж байгаа ажлууддаа эзэн болоод хийхгүй бол одоо энэ 5 номер дээр сууж байгаа хүн засаг байгуулагдаад дахиад түр орлон гүйцэтгэгч Монгол Улсын Засгийн газар явсаар байгаад бүх асуудлууд нь түр орлон гүйцэтгэгч нар гэж нэг тухайн үедээ нэг жоохон сандал бөглөж суудаг юм уу яадаг юм. Байж байгаад л асуудал нь, ажил нь ард нь тэр чигээрээ хоцорч байна. Хэдэн хүн тухайн үед нэг ажил хийсэн болоод л хоцордог. 2017 оноос хойш энэ тавхан төсөл дээр авсан энэ нэг жоохон ажлуудаа тухайн үед нь шуурхай яагаад хийчхэж болоогүй юм бэ? Иймэрхүү байдлаар асуудалд хандаад байвал дараа дараагийн бүх зээлүүд л хугацаа сунгая гэж орж ирэх нь байна шүү дээ.

Тэгээд нөгөө төсөв чинь хүндрээд байна. Төсөв төсвийн орлого нь тасраад байна. Гадаад зээлийн ашиглалтыг бид нар сайжруулж чадахгүй байна гэдэг асуудлууд чинь ажлаа хийж чадахгүй байгаагаас шалтгаалж бас орж ирж байна шүү гэдгийг бас анхааруулж хэлэх гэсэн юм. Энэ дээр энэ Ерөнхий сайд байдаг юм уу? Холбогдох сайд нар энэ Сангийн сайд, БХБ-ын сайд бүгдээрээ анхаарлаа хандуулаад хийгдэх гэж байгаа ажлуудаа цаг хугацаанд нь болж байгаа бол цаг

хугацаанаас нь өмнө хийгээд ийм хийгээд ийм гоё, ийм гоё нөхцөлтэй зээлүүдийг цаг хугацаанд нь ашиглаж сурмаар байна л гэдгийг хэлэх гэсэн юм.

Н.Наранбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалттай гишүүд санал хураалтад бэлтгэе. Заяабал гишүүн санал хураалтдаа бэлд. Ирцийн санал хураалт явуулаадахъя эхлээд. Ирцийн санал хураалт.

Одоо санал хураалт явна. Би томъёоллыг уншчихъя.

Улаанбаатар хотноо 2017 оны 5 сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг зөвшөөрч гарын зүсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

30 гишүүнээс 17 гишүүн дэмжиж 56.7 хувиар дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ ээ.

Улаанбаатар хотноо 2017 оны 5 сарын 9-ний өдөр байгуулсан Монгол Улсын Засгийн газар, БНПУ-ын Засгийн газар хоорондын нөхцөл зээлийн ерөнхий хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хавсралтын төслийг хэлэлцэж дууслаа.

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Байнгын хороодын хамтарсан хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. баярлалаа.

15.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА